



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Х.ГАНХУЯГ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2022.03.25 № 1/1639

танай 2022.03.09-ны № 05 -Т

Хариу хүргүүлэх тухай

Захиргааны ерөнхий хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэгт “Захиргааны хэм хэмжээний акт гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй шийдвэрийг ойлгоно” гэж заасан шинжийг агуулсан шийдвэрийг эрх бүхий захиргааны байгууллагаас батлан гаргах, хянан бүртгэх, хэрэгжилтэд хяналт тавихтай холбоотой харилцааг Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Захиргааны ерөнхий хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд зохицуулж байна.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “..Засгийн газар хуулиар тусгайлан эрх олгосон тохиолдолд хуульд нийцүүлэн бүрэн эрхийнхээ хүрээнд захиргааны хэм хэмжээний акт гаргаж болох бөгөөд тогтоол хэлбэртэй байна. Засгийн газар захиргааны хэм хэмжээний акт гаргахдаа тусгайлан эрх олгосон хуулийг иш үндэс болгоно” гэж, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Засгийн газраас баталсан захиргааны хэм хэмжээний акт /Засгийн газрын тогтоол/-ыг Улсын Их Хуралд хүргүүлнэ” гэж, мөн зүйлийн 1 дэх хэсэгт “Захиргааны хэм хэмжээний актыг хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллага батална” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Захиргааны хэм хэмжээний актыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянаж, бүртгэнэ” гэж тус тус заасан хүрээнд захиргааны хэм хэмжээний акт батлах, хянан бүртгэх ажиллагааг хийж байна.

Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд тус яамны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд сайд, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлаг, Засгийн газрын бус бие даасан агентлаг болон эрх шилжүүлэн авсан нийтийн эрх зүйн этгээд нийт 104 байгууллагаас баталсан 2200 актыг бүртгэж авсан байна. Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй актын мэдээллийг эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем /www.legalinfo.mn/-д цахим хэлбэрээр мөн байршуулдаг. (Захиргааны хэм хэмжээний актын 2022 оны эмхэтгэлийг хавсарган хүргүүлэв)

Түүнчлэн тус яамны “Захиргааны хэм хэмжээний актын хяналт, бүртгэл, тайлангийн систем”-ийн мэдээллийн бааз бэлтгэх хүрээнд хийгдсэн судалгаагаар 2021 оны 10 сарын байдлаар нийт хүчин төгөлдөр, бие даасан 511 хууль дахь 3835

151601645

эрх олгосон заалтыг системд оруулж, холбоос хийх ажиллагаа үргэлжлэн хийгдэж байна.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу Засгийн газар төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын шийдвэр хууль тогтоомжид нийцэж буй эсэхэд хяналт тавих бүрэн эрхээ хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газрын 2021 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн хуралдааны 30 дугаар тэмдэглэлээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгэлтэй, нийтээр дагаж мөрдүүлэх шийдвэрийн хэрэгжилтийн байдал болон цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг даалгасны дагуу тус яамнаас 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн Засгийн газрын хуралдаанд Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй шийдвэрт хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг танилцуулсан ба Засгийн газрын хуралдааны 62 дугаар тэмдэглэл гарч, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Захиргааны ерөнхий хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д “Хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хүчин төгөлдөр үйлчилж байгаа захиргааны хэм хэмжээний актад жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтийн явц, үр дүнгийн тайланг цаашид авах арга хэмжээний талаарх саналын хамт хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ” гэж заасны дагуу 2021 оны 7 дугаар сарын 30-ны өдрөөр тасалбар болгон нийт 1976 шийдвэрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг захиргааны хэм хэмжээний актыг баталсан захиргааны байгууллагаар хийлгэж, мөн зүйлийн 69.3 дахь хэсэгт “Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас ирүүлсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, төлөвлөгөө, саналыг нэгтгэн судалж, цаашид авах арга хэмжээний талаарх саналаа Засгийн газарт танилцуулна” гэж заасан чиг үүргийн хүрээнд тус яам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн үр дүнгийн тайлан, цаашид авах арга хэмжээний талаарх саналаа нэгтгэн Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг хавсаргав.

Хавсралт: 8.хуудастай, эмхэтгэл 1 ширхэг



Х.НЯМБААТАР

**МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС**

ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮДЭД

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн хуралдааны 62 дугаар тэмдэглэл:

"1. ХЭЛЭЛЦСЭН НЯ:

Улсын нэгдсэн санд бүртгэлтэй захиргааны хэм хэмжээний актэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн үр дүнгийн тайлан, цаашид авах арга хэмжээний тухай

ШИЙДВЭРЛЭСЭН НЯ: 1. Захиргааны байгууллагуудын хүнд суртлыг багасгах, тэдгээрийн шийдвэр гаргах чадавхыг бэхжүүлэх, иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, Засгийн газрын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй, ил тод болгох зорилгоор улсын нэгдсэн санд бүртгэлтэй захиргааны хэм хэмжээний актэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн үр дүнгийн тайлан, цаашид авах арга хэмжээний талаар хэлэлцээд, дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт даалгаж, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газрын бүс бие даасан агентлаг болон эрх шилжүүлэн авсан нийтийн эрх зүйн этгээдийн эрх бүхий албан тушаалтнуудад зөвлөв:

1.1. Эрхэлсэн асуудал, чиг үүргийнхээ дагуу захиргааны хэм хэмжээний актыг улсын нэгдсэн санд бүртгэлтэй шийдвэрүүдийг хууль тогтоомжийн өөрчлөлттэй уялдуулан хянан үзэж, холбогдох саналаа хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэх;

1.2. ач холбогдлоо алдаж дагаж мөрдөхөө больсон, хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн, хууль зүй, дотоод хэргийн яамнаас хүчингүй болгох дүнгэлт гаргах хүргүүлсэн боловч хүчингүй болгоогүй, мөн хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын хүрээнд хуульд нийцүүлэхээр ажиглаж байгаа талаар харйу ирүүлсэн шийдвэрүүдийг дүнгэлтийн дагуу хүчингүй болгож, хуульд нийцүүлэх арга хэмжээг авч 2021 оны 4 дүгээр улиралд багтаан хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэх;

1.3. өөрийн салбарт дагаж мөрдөгдөж байгаа хуулиудаас тусгайлан эрх олгогдсон заалтын судалгааг гарган, батлах зохицуулалттай боловч бүртгэлд бүртгүүлэхгүйгээр дагаж мөрдөж байгаа шийдвэрүүдийг хянан үзэж, тэдгээрийг батлах, бүртгүүлэх арга хэмжээг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан хэрэгжүүлэх;

1.4. Захиргааны ерөнхий хуулийг үйл ажиллагаандаа дагаж мөрдөн хэвшүүлэх, цаашид уг хуультай холбоотой зөрчил гаргахгүй байх, гаргасан тохиолдолд холбогдох албан тушаалтанд харийчллага тооцож ажиглах.

2.1. захиргааны хэм хэмжээний актыг улсын нэгдсэн санд бүртгэлтэй захиргааны хэм хэмжээний акт (цаашид "тушаал, захирамж, тогтоол" гэхэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд тусгавдсан хууль зүй, дотоод хэргийн сайдын дүнгэлт болон хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн хүрээнд хуульд нийцүүлэхээр ажиглаж байгаа гэсэн харйу ирүүлсэн шийдвэрийн жагсаалтыг ангилан гаргаж, холбогдох захиргааны байгууллагад хүргүүлэх;

2.2. бүтцийн өөрчлөлттэй холбоотойгоор холбогдох захиргааны байгууллага байхгүй болсон нөхцөлд эрх залгамжлагсан, чиг үүргийг нь шилжүүлэн авсан захиргааны байгууллагад тухайн захиргааны хэм хэмжээний актыг хүргүүлэх;

2.3. захиргааны хэм хэмжээний актыг улсын нэгдсэн санд бүртгэлтэй шийдвэрийг шинэчлэн баталсан, хүчингүй болгосон болон нэмэлт, өөрчлөлт оруулсан шийдвэрийг тухай бүр ирүүлэхгүйгээр улсын нэгдсэн санд бүртгэлтэй хэвээр байгаа актыг жагсаалтыг гаргаж, холбогдох захиргааны байгууллагад хүргүүлэх;

2.4. холбогдох захиргааны байгууллагуудаас ирүүлсэн шийдвэрийг үндэслэн захиргааны хэм хэмжээний актыг улсын нэгдсэн бүртгэлд зохиж хөдөлгөөнийг хийж;

2.5. холбогдох захиргааны байгууллага шийдвэрээ хүчингүй болгох үндэслэлгүй гэж үзсэн тохиолдолд асуудлыг Засгийн газрын хуралдаанд оруулж эцэслэн шийдвэрлүүлэх.

3. Захиргааны байгууллагууд энэ тэмдэглэлийн 2.1, 2.2, 2.3-т заасан шийдвэрээс гадна захиргааны хэм хэмжээний актыг улсын нэгдсэн санд бүртгэлтэй бусад шийдвэрээ дарааж чиглэлээр хянан үзэж, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бичгээр мэдэгдэх;

3.1. хүчингүй болсон тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх;

3.2. ач холбогдлоо алдсан, дагаж мөрдөгдөхгүй тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх;

3.3. нэмэлт, өөрчлөлт оруулсан буюу хөдөлгөөн хийдгээгүй тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх;

3.4. хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх;

3.5. хуулиар тусгайлан эрх олгогдсон боловч батлаагүй тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх;

3.6. улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхгүйгээр даган мөрдөж байгаа тушаал, захирамж, тогтоол байгаа эсэх;

3.7. Тэмдэглэлийн 3.2, 3.4-т заасан захиргааны хэм хэмжээний актыг талаарх мэдээллийг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв

байгууллагад хүргүүлэхдээ зохих албан тушаалтан тэдгээрийг хүчингүй болгох шийдвэр гаргаж, хавсаргасан байх.


4. Дараахь асуудлыг судалж, холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулан 2022 оны эхний улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Засгийн газрын гишүүдэд даалгав:

4.1. нийтээр дагаж мөрдүүлэх, зайлшгүй шаардлагатай, хууль тогтоомжоор тусгайлан эрх олгогдоогүй шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг холбогдох хуульд тусгах;

4.2. хуульд тусгайлан заасан боловч баталж мөрдүүлэх шаардлагагүй шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг нягтлан үзэх.

5. Хууль зүй, дотоод хэргийн сайдын сайдын дүгнэлтийг үндэслэн зарим төрийн захиргааны төв байгууллагын нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан хууль тогтоомжид нийцээгүй шийдвэрийг Ерөнхий сайдын захирамжаар хүчингүй болгохоор тогтов.

6. Энэ тэмдэглэлийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарт даалгав." гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

ТАНИЛЦУУЛГА

Улсын нэгдсэн санд бүртгэлтэй захиргааны хэм хэмжээний актад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн үр дүнгийн тайлан, цаашид авах арга хэмжээний тухай/

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу Засгийн газар нь төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын шийдвэр хууль тогтоомжид нийцэж буй эсэхэд хяналт тавих бүрэн эрхтэй.

Мөн хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 7 дахь заалтад заасны дагуу төрийн захиргааны байгууллагын шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг хянах асуудал нь Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаардаг бөгөөд энэ үйл ажиллагааг Захиргааны ерөнхий хуулийн 65 дугаар зүйлийн 65.1 дэх хэсэгт “Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага захиргааны хэм хэмжээний актыг бүртгэхдээ энэ хуулийн 60, 61, 62 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянаж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгэнэ” гэж заасны дагуу хэрэгжүүлэн ажиллаж байна.

Захиргааны ерөнхий хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д “Хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хүчин төгөлдөр үйлчилж байгаа захиргааны хэм хэмжээний актад жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтийн явц, үр дүнгийн тайланг цаашид авах арга хэмжээний талаарх саналын хамт хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.” гэж, мөн зүйлийн 69.3 дахь хэсэгт “Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас ирүүлсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, төлөвлөгөө, саналыг нэгтгэн судалж, цаашид авах арга хэмжээний талаарх саналаа Засгийн газарт танилцуулна.” гэж тус тус заасан.

Үүнтэй холбогдуулан Засгийн газрын 2021 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн хуралдааны 30 дугаар тэмдэглэлийн 2 дахь заалтад Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгэлтэй нийтээр дагаж мөрдүүлэх шийдвэрийн хэрэгжилтийн байдал болон цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулж 2021 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайдад даалгасан.

Хуулийн дээрх заалт болон Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилтийг хангах хүрээнд тус яамны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй 102 байгууллагын нийт 2063 шийдвэрийг холбогдох

захиргааны байгууллагад хүргүүлэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн үр дүнгийн тайлан, цаашид авах арга хэмжээний талаарх саналаа Засгийн газрын хуралдаанд танилцуулж байна.

Захиргааны ерөнхий хуулийн 66 дугаар зүйлийн 66.3.2 дахь заалтад “захиргааны хэм хэмжээний акт бүхэлдээ, эсхүл түүний аль нэг заалт энэ хуулийн 60, 61, 62 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд уг зөрчлийг арилгуулах тухай тодорхой үндэслэл, тайлбар бүхий дүгнэлт гаргаж, албан бичгээр хүргүүлэх;” гэж заасан.

Хууль зүй, дотоод хэргийн яам 2021 оны 7 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн 2021 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийг дуустал улсын нэгдсэн санд бүртгэлтэй 2063 захиргааны хэм хэмжээний актад хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг хийхдээ сайд, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлаг, Засгийн газрын бус бие даасан агентлаг болон эрх шилжүүлэн авсан нийтийн эрх зүйн этгээдээс баталсан нийт 1976 шийдвэрийг 2021 оны 7 дугаар сарын 30-ны өдрөөр тасалбар болгон хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг холбогдох байгууллагаар хийлгэснээр 5 шийдвэрийг Захиргааны ерөнхий хууль болон холбогдох хуульд нийцүүлэн хүчингүй болгосон, 1 шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулсан шийдвэрийг тус тус хүлээн авснаар улсын нэгдсэн санд холбогдох хөдөлгөөнийг хийж зөрчлийг арилгасан /Хавсралт 1/, 2 шийдвэрийг нийтээр дагаж мөрдүүлэх хэм хэмжээ тогтоогоогүй, тухайн салбарын дотоод асуудлыг зохицуулсан тул улсын нэгдсэн бүртгэлээс хасаж, 3 шийдвэрийн улсын нэгдсэн болон салбарын сангийн хоорондох зөрчлийг арилгаж, 131 шийдвэрийг дүгнэлт болон хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын хүрээнд хуульд нийцүүлэх ажиллагаа хийж байгаа /дүгнэлтийн дагуу журмуудыг хүчингүй болгохоор уг асуудлууд зохицуулалтгүй болж эмх замбараагүй байдал үүсэх учраас журам батлах эрх олгосон заалтыг шинээр батлагдах хууль, шинэчилсэн найруулга, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах зэргээр ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байгаа, хуулийн төсөл боловсруулагдаж байгаа болон өргөн барьсан, УИХ-аар хэлэлцэж байгаа тул батлагдах хүртэл уг журмуудыг хэвээр мөрдөх саналтай байгаа/ гэсэн хариуг холбогдох захиргааны байгууллагуудаас ирүүлснийг нэгтгэн гаргасан байна. /Хавсралт 2/

Үүнтэй холбогдуулан улсын нэгдсэн санд бүртгэлтэй 102 байгууллагын баталж, бүртгүүлсэн шийдвэрийн тэмдэглэх хэсэгт үндэслэл болгосон хуулийн заалтыг шалган үзэхэд 11 байгууллагын 93 шийдвэрийн үндэслэл болгосон хууль хүчингүй болж эрх олгосон заалтад өөрчлөлт орсон /Эрүүл мэндийн тухай хууль 2011 онд батлагдан 11 удаагийн нэмэлт, өөрчлөлт орсон, Авто замын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2017 он, Барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2016 онд тус тус батлагдсан/, түүнчлэн Эм, эмнэлгийн хэрэгслэлийн тухай хууль, Шүүх шинжилгээний тухай хуулиар хамтарч батлах эрх олгосон этгээдтэй хамтран батлаагүй, Ашигт малтмалын тухай хууль, Хадгаламж зээлийн хоршооны тухай хууль, Газрын тухай хуулиар уг журмыг батлах эрх олгогдоогүй, түүнчлэн Засгийн газрын тогтоолыг үндэслэл болгосон болон үндэслэл болгосон хуулийн заалт байхгүй зэрэг шийдвэрийн жагсаалтыг /Хавсралт 3/

тэмдэглэх хэсэгт үндэслэл болгосон эрх олгосон хуулийн зохицуулалт хүчингүй болсон болон уг журмыг батлах эрх өөр этгээдэд шилжсэн холбогдуулан хуульд нийцүүлэх арга хэмжээ авах шаардлагатай 5 байгууллагын 8 шийдвэрийн жагсаалтыг /Хавсралт 4/, харин 5 шийдвэрийг хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн хүрээнд Зам тээврийн хөгжлийн яам хүчингүй болгох саналтай байгаагаар илэрхийлсэн байна. Тодруулбал, Дэд бүтцийн хөгжлийн сайдын 2 тушаал, Зам, тээвэр, барилга хот байгуулалтын сайдын 2 тушаал, Зам, тээврийн сайд, Сангийн сайд, Төрийн өмчийн хорооны даргын хамтарсан 1 тушаал. /Хавсралт 5/

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй шийдвэрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх явцад дараах нийтлэг зөрчил дутагдлууд харагдаж байна.

- Тэмдэглэх хэсэгт хуулиар тусгайлан эрх олгогдсон хуулийн зүйл, заалтыг үндэслэл болгоогүй, үндэслэл болгосон хууль хүчингүй болсон боловч хуульд нийцүүлэх арга хэмжээг аваагүй, түүнчлэн ерөнхий болон огт хамааралгүй заалт үндэслэсэн алдааг гаргасаар байна.
- Ач холбогдлоо алдсан, эрх зүйн үйлчлэлийн хугацаа дуусгавар болсноор дагаж мөрдөхгүй байгаа шийдвэрүүдийг холбогдох байгууллагууд хүчингүй болгосон гэх боловч хүчингүй болгосон, нэмэлт, өөрчлөлт оруулсан шийдвэрүүдээ цаг тухайд нь ирүүлээгүйгээс улсын нэгдсэн сангийн бүртгэлээс хасагдаагүй, холбогдох хөдөлгөөн хийгдээгүйгээс санд бүртгэлтэй хэвээр байх зэрэг зөрчлүүд гарсаар байна. Тодруулбал иргэн, хуулийн этгээдийн хүсэлт болон шүүхээс хэрэг маргааныг эцэслэн шийдвэрлэхтэй холбогдуулан уг шийдвэр санд бүртгэлтэй эсэх талаар лавлагаа, мэдээлэл өгөх явцад болон бусад мэдээллийн хүрээнд илэрч гарч ирсээр байна.
- Хуульд 3 байгууллага хамтарч батлахаар заасан байхад 2 байгууллага батлах, баталсан шийдвэрийг хүчингүй болгох тохиолдолд хамтарч баталсан байгууллагын саналыг авахгүйгээр шийдвэрийг дангаар хүчингүй болгох зэрэг зөрчлүүд байна.
- Баталсан шийдвэрээ ажлын 5 өдрийн дотор, нэмэлт, өөрчлөлт оруулсан болон хүчингүй болгосонд тооцсон тохиолдолд уг шийдвэрийг ажлын 3 өдөрт багтаан хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар хянуулж, бүртгүүлэх болон хөдөлгөөн хийлгэх хуулийн хугацааг баримталж ажиллахгүй асуудал байсаар л байна.
- Сум, дүүргийн Засаг дарга гаргасан шийдвэрээ ажлын 10 өдөрт багтаан дээд шатны Засаг даргаар дамжуулан хянуулж, бүртгүүлэхээр ирүүлэх хуулийн хэрэгжилт хангалтгүй байна. Тухайлбал сум, дүүргийн Засаг даргын баталсан шийдвэрийг хянах явцад дээд шатны Засаг дарга доод шатны Засаг даргын баталсан шийдвэр хуульд нийцэж байгаа эсэхийг гүйцэд хянахгүй, зөвхөн дамжуулагчийн үүрэг гүйцэтгэснээс хянуулж,

бүртгүүлэхээр ирүүлсэн шийдвэрүүд Захиргааны ерөнхий хууль болон холбогдох бусад хуульд нийцээгүйгээс буцах тохиолдол гарсаар байна.

- Захиргааны байгууллагаас баталсан захиргааны хэм хэмжээний акт нь Захиргааны ерөнхий хуульд заасан тавигдах шаардлагыг хангахгүй тохиолдолд Хууль зүй, дотоод хэргийн яамнаас уг зөрчлийг арилгуулахаар дүгнэлт хүргүүлсэн тохиолдолд хуульд заасан хугацаанд хариу ирүүлэхгүй зөрчлүүд гарсаар байна.
- Зарим байгууллага Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу салбарын сан хариуцсан ажилтанг томилоогүйгээс тухайн байгууллагын баталсан захиргааны хэм хэмжээний актын тоо улсын нэгдсэн санд бүртгэлтэй актын тооноос зөрсөн зөрчлүүд гарсаар байна.
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон тэдгээрийн Засаг дарга нар хууль тогтоомжоор тусгайлан эрх олгогдсон асуудлаар захиргааны хэм хэмжээний актаа батлан, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлснээр дагаж мөрдүүлэх холбогдох хуулийн хэрэгжилт хангалтгүй байсаар л байна. Өөрөөр хэлбэл дээрх байгууллагуудаас баталж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн шийдвэрийг төрлөөр нь гарган баталсан байгууллага тус бүрээр судалгааг гаргаж үзэхэд хуулиар тусгайлан эрх олгогдсон шийдвэрээ бүртгүүлээгүй аймаг, нийслэл, сум, дүүрэг олон байна. Жишээлбэл, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэгт “Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох журмыг харьяалах нутаг дэвсгэрийн иргэдийн саналыг авсны үндсэн дээр батална.” гэж заасан хуулийн хэрэгжилтийг 22 байгууллага баталж ирүүлэхээс дөнгөж 14 аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал журмаа баталж, шийдвэрээ бүртгүүлсэн байх бөгөөд үлдсэн нийслэл болон бусад 7 аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал уг шийдвэрийг баталсан эсэх нь тодорхойгүй байна. /Хавсралт 6, 7/
- Улсын нэгдсэн санд бүртгэлтэй шийдвэрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ирүүлсэн тайлантай танилцах явцад зарим байгууллагын хуулийн хэлтэс хууль зүйн талаас нь хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж цаашид авах арга хэмжээний саналыг бэлтгэн ирүүлээгүйгээс хангалтгүй тайлан ирүүлсэн байна. Тухайлбал “хэрэгжилт” гэсэн баганад эрх зүйн үндэслэлийг шалгаж үнэлэлт, дүгнэлт өгөөгүйгээс хуулиар уг журмыг батлах эрх олгосон заалт хүчингүй болсон, эсхүл өөр этгээд батлахаар хуульд нэмэлт, өөрчлөлт орсон байхад хуульд нийцүүлэх арга хэмжээг авахаар саналаа илэрхийлэхгүй, хэвээр мөрдөнө гэсэн санал ирүүлсэн. Түүнчлэн “хэрэгжилт” гэсэн баганад уг журмын зүйл, заалтын хэрэгжилт хангалтгүй байгаа талаар мэдээлээд байгаа боловч “үнэлгээ” гэсэн баганад 90, 100 хувь гэж үнэлчихээд “санал” гэсэн баганадаа хүчингүй болгоно, эсхүл хэвээр мөрдөнө гэх мэтээр уялдаа холбоогүй, ойлгомжгүй тайланг хийсэн

байна. Мөн улсын нэгдсэн санд бүртгүүлээгүй шийдвэрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж саналаа илэрхийлсэн байна.

Иймд захиргааны хэм хэмжээний акттай холбоотой нийтлэг гарч байгаа дээрх зөрчил, дутагдлыг арилгах талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлд заасан захиргааны байгууллагуудын удирдлагад даалгасан Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл, Ерөнхий сайдын захирамжийн төслийг тус тус боловсрууллаа:

Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөлд:

- Ач холбогдлоо алдсан, эрх зүйн үйлчлэлийн хугацаа дууссан, хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хүчингүй болгох дүгнэлт хүргэгдсэн боловч хүчингүй болгоогүй захиргааны хэм хэмжээний актуудыг хүчингүй болгох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Засгийн газрын гишүүн, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газрын бус бие даасан агентлаг болон эрх шилжүүлэн авсан нийтийн эрх зүйн этгээдийн эрх бүхий албан тушаалтнуудад хууль тогтоомжоор тусгайлан эрх олгосон боловч өнөөг хүртэл баталж мөрдүүлээгүй байгаа захиргааны хэм хэмжээний актуудыг батлах арга хэмжээ авах;
- Захиргааны ерөнхий хуулийн Зургаадугаар бүлгийг төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд дагаж мөрдүүлэн хэвшүүлэх, цаашид зөрчил гаргахгүй байхыг Засгийн газрын гишүүн, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт үүрэг болгож, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газрын бус бие даасан агентлаг болон эрх шилжүүлэн авсан нийтийн эрх зүйн этгээдийн эрх бүхий албан тушаалтнуудад зөвлөх.

Харин дараах шийдвэрүүдийг эцэслэн шийдвэрлүүлэх Ерөнхий сайдын захирамжийн төсөлд:

- Холбогдох захиргааны байгууллагуудаас дүгнэлт болон хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын хүрээнд хүчингүй болгох санал ирүүлсэн 5 шийдвэр байна. Үүнд: Захиргааны ерөнхий хуулийн 69 дүгээр зүйлийн 69.4 дэх хэсэгт “Улсын нэгдсэн санд бүртгэлтэй боловч Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчид өөрчлөлт орсны улмаас эрхлэн хариуцах байгууллага нь тодорхойгүй болсон захиргааны хэм хэмжээний актыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Засгийн газрын хуралдаанд танилцуулж, эцэслэн шийдвэрлүүлнэ” гэж заасны дагуу Ерөнхий сайдын захирамжаар эцэслэн шийдвэрлүүлэх саналтай дараах шийдвэрүүд байна.

- Зам, тээврийн сайд, Сангийн сайд, Төрийн өмчийн хорооны даргын хамтарсан 2013 оны А/06/290/314 дүгээр тушаал,
 - Дэд бүтцийн хөгжлийн сайдын 1998 оны 248 дугаар тушаал.
- Хавсралтуудыг хүчингүй болгосон боловч үндсэн тушаалыг хүчингүй болгох тухай шийдвэр гаргаж ирүүлээгүй тул эх тушаал нь хүчинтэй хэвээр, улсын нэгдсэн сангаас хасалт хийгдээгүй тул Ерөнхий сайдын захирамжаар эцэслэн шийдвэрлүүлэх саналтай дараах шийдвэрүүд байна:
 - Дэд бүтцийн хөгжлийн сайдын 1998 оны 282 дугаар тушаал,
 - Мөн ЗТБХБ Сайдын 2010 оны 77, 78 дугаар тушаалууд.

Энэ ажлын хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн сайдаас хүргүүлсэн дүгнэлтийн хүрээнд хүчингүй болгосон болон нэмэлт, өөрчлөлт оруулсан шийдвэрийн жагсаалтыг нэгдүгээр, Захиргааны ерөнхий хууль болон холбогдох хуульд нийцүүлэхээр ажиллагаа хийж байгаа гэсэн хариу ирүүлсэн шийдвэрийн жагсаалтыг хоёрдугаар, Санд бүртгэлтэй актын тэмдэглэх хэсэгт үндэслэл болгосон хуулиар эрх олгогдоогүй, хуулиар эрх олгосон этгээдтэй хамтран батлаагүй шийдвэрийн жагсаалтыг гуравдугаар, Эрх олгосон хуулийн зохйцуулалт өөрчлөгдсөнтэй холбогдуулан хуульд нийцүүлэх арга хэмжээ авах шаардлагатай шийдвэрийн жагсаалтыг дөрөвдүгээр, Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд ажиллагаа хийгээгүй шийдвэрийн жагсаалтыг Засгийн газрын хуралдаанд оруулж шийдвэр гаргуулах шийдвэрийн жагсаалтыг тавдугаар, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын баталсан шийдвэрийн төрлийн судалгааг зургаадугаар, Аймаг, нийслэлийн Засаг даргын баталсан шийдвэрийн төрлийн судалгааг долоодугаар, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн нэгтгэлийг наймдугаар хавсралтаар тус тус нэгтгэн гаргалаа.

Хоёр, гурав, дөрөвдүгээр хавсралтад орсон шийдвэр тус бүрийг нягталж, цэгцлэх ажлыг Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төслийн дагуу Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газрын бус бие даасан агентлаг болон эрх шилжүүлэн авсан нийтийн эрх зүйн этгээдийн эрх бүхий албан тушаалтан нар хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

Цаашид Засгийн газрын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй, ил тод болгох, төрийн зохицуулалтын үр нөлөөг дээшлүүлэх арга хэмжээг байнга хэрэгжүүлж, Захиргааны ерөнхий хуулийн Зургаадугаар бүлгийг үйл ажиллагаандаа мөрдүүлж хэвшүүлэх, нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэртээ тогтмол дүн шинжилгээ хийж, шинээр батлагдсан хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрээ тухай бүр нь нэмэлт, өөрчлөлт оруулж байх шаардлагатай байна. Түүнчлэн Хууль зүй, дотоод хэргийн сайдаас хүргүүлсэн дүгнэлтийн дагуу шуурхай арга хэмжээ авч ажиллах, хуулиар тусгайлан эрх олгогдоогүй асуудлаар дүрэм, журам батлах, хуулиар олгогдсон эрх хэмжээгээ хэтрүүлэх болон нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрээ хянуулж,

бүртгүүлэхгүйгээр дагаж мөрдүүлдэг явдлыг таслан зогсоож, шийдвэрийг баталснаас хойш ажлын 5 өдрийн дотор хянуулж, бүртгүүлэх хугацааг баримталж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хянуулж, бүртгүүлсэн шийдвэрүүдээр салбарын сан байгуулж, иргэдэд үйлчлэх үүргээ биелүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт анхааруулж, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газрын бус бие даасан агентлаг болон эрх шилжүүлэн авсан нийтийн эрх зүйн этгээдийн эрх бүхий албан тушаалтнуудад зөвлөж байна.

-----oOo-----



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2022.03.25 № 1/1640.

танай 2022.03.09 онд № 171 -Т

УВС АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА
Ц.БАТБОЛД ТАНАА

Увс аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны “Газрын төлбөрийн бүсийн хил зааг, итгэлцүүр төлбөрийн хэмжээг тогтоох тухай” 7/07 дугаар тогтоолыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянан үзээд Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн ...5768 дугаарт бүртгэснийг үүгээр мэдэгдье.



Х.НЯМБААТАР



**УВС АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРАЛ**

3 дугаар баг, Улаангом, Увс аймаг, 85165

Утас/Факс: 7045-2113

Цахим шуудан: info@khural.uv.gov.mn

Цахим хуудас: www.uvs.khural.mn

2022. 03. 09 № 171

танай _____ -ны № _____ -т

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН ЯАМАНД**

Аймгийн ИТХ-аар 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдөр хэлэлцэн баталсан Газрын төлбөрийн бүсийн хил зааг, итгэлцүүр, төлбөрийн хэмжээг тогтоох тухай тогтоолыг хянаж, захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгэж өгнө үү.

Хавсралт 26 хуудастай.

ДАРГА

Ц. БАТБОЛД



F /disk/ хурлын албан тоот А5

9599000170



**УВС АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРАЛ**

3 дугаар баг, Улаангом, Увс аймаг, 85165

Утас/Факс: 7045-2113

Цахим шуудан: info@khural.uv.gov.mn

Цахим хуудас: www.uvs.khural.mn

2022. 03. 09 № 171

танай _____ -ны № _____ -т

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН ЯАМАНД**

Аймгийн ИТХ-аар 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдөр хэлэлцэн баталсан Газрын төлбөрийн бүсийн хил зааг, итгэлцүүр, төлбөрийн хэмжээг тогтоох тухай тогтоолыг хянаж, захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгэж өгнө үү.

Хавсралт 26 хуудастай.

ДАРГА

Ц. БАТБОЛД

F /disk/ хурлын албан тоот А5

9522111188



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2022 оны 03 сарын 31
өдрийн 5768

УВС АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 03 сарын 03 өдөр

Дугаар 7107

Улаангом

Газрын төлбөрийн бүсийн хил зааг, итгэлцүүр, төлбөрийн хэмжээг тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14 дэх заалт, Газрын төлбөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. Увс аймгийн Улаангом сумын газар нутгийн байршил, суурьшлын бүс, нийгэм эдийн засгийн онцлогийг харгалзан газрын үнэлгээний бүсийг 1 дүгээр хавсралтаар, "Улаангом сумын газрын төлбөрийн итгэлцүүр, газрын төлбөрийн хэмжээ"-г 2 дугаар хавсралтаар, "Баруунтуруун сумын газрын төлбөрийн итгэлцүүр газрын төлбөрийн хэмжээ"-г 3 дугаар хавсралтаар, "Бөхмөрөн сумын газрын төлбөрийн итгэлцүүр газрын төлбөрийн хэмжээ"-г 4 дүгээр хавсралтаар, "Завхан сумын газрын төлбөрийн итгэлцүүр, газрын төлбөрийн хэмжээ"-г 5 дугаар хавсралтаар, "Зүүнговь сумын газрын төлбөрийн итгэлцүүр, газрын төлбөрийн хэмжээ"-г 6 дугаар хавсралтаар, "Малчин сумын газрын төлбөрийн итгэлцүүр, газрын төлбөрийн хэмжээ"-г 7 дугаар хавсралтаар, "Хяргас сумын газрын төлбөрийн итгэлцүүр, газрын төлбөрийн хэмжээ"-г 8 дугаар хавсралтаар, бусад сумдын газрын төлбөрийн итгэлцүүр, газрын төлбөрийн хэмжээ"-г 9 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Газрын төлбөрийн бүсчлэл, итгэлцүүр, газрын төлбөрийн хэмжээг мөрдүүлж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг аймаг, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Тогтоолыг Захиргааны ерөнхий хуульд заасан шаардлагыг хангаж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Дамдинсүрэн)-д даалгасугай.

ДАРГА

Ц.БАТБОЛД



0582001020

Улаангом сумын газрын үнэлгээний бүс

Эргэлтийн цэгийн дугаар	Үнэлгээний бүс	Үнэлгээний бүсийн байршил, хил хязгаар	Бүсийн солбицол	
			х	у
1	1-р бүс	1 дүгээр бүсэд сумын төвийн 3,4,5,7,10,11,12 дугаар багуудын нутаг инженерийн шугам, сүлжээ бүхий газар 3, 7, 10, дүгээр багуудын нутаг хамаарна. Эргэлтийн цэгийн эхлэл нь 8 дугаар цэцэрлэгийн урд талын замын уулзвараас эхлэн авто замын дагуу 6 дугаар сургуулийн дээд талын гурван замын уулзвар, Цастогтох дэлгүүр, Орсын машины зогсоолын урдуур шороон замаар явж, Дулааны станцын зүүн талаар явсан шороон замаар Шунхлай ШТС-ийн уулзвар, хуучин нисэх буудлын талбайг оруулан УЦУОША-ны дээд талаар Улаан уулын пост хүрэх шороон замтай нийлэн арын гудамжны эхээр 27 га доод талаар улаан уулын 3 замын уулзвараас баруун зам дэлгүүрийн арын уулзвараас баруун 4 замын уулзвар хүрээд 3 дугаар сургуулийн арын засмал зам дагуу 8 дугаар цэцэрлэгийн урд талын уулзвар дээр дуусан.	92° 5' 2.922" E	49° 59' 16.969" N
2			92° 5' 8.739" E	49° 59' 12.748" N
3			92° 5' 8.207" E	49° 59' 11.260" N
4			92° 5' 9.479" E	49° 59' 5.858" N
5			92° 5' 6.846" E	49° 58' 57.472" N
6			92° 5' 5.681" E	49° 58' 55.204" N
7			92° 5' 2.772" E	49° 58' 52.924" N
8			92° 5' 1.077" E	49° 58' 51.422" N
9			92° 5' 0.610" E	49° 58' 49.543" N
10			92° 5' 3.125" E	49° 58' 44.812" N
11			92° 5' 15.240" E	49° 58' 44.681" N
12			92° 5' 9.871" E	49° 58' 41.149" N
13			92° 5' 5.962" E	49° 58' 31.934" N
14			92° 5' 1.281" E	49° 58' 23.545" N
15			92° 5' 0.160" E	49° 58' 21.864" N
16			92° 4' 57.345" E	49° 58' 17.029" N
17			92° 4' 50.549" E	49° 58' 18.733" N
18			92° 4' 39.566" E	49° 58' 16.971" N
19			92° 4' 36.196" E	49° 58' 15.780" N
20			92° 4' 33.257" E	49° 58' 15.554" N
21			92° 4' 31.955" E	49° 57' 59.034" N
22			92° 4' 30.842" E	49° 57' 56.452" N
23			92° 4' 29.525" E	49° 57' 56.656" N
24			92° 4' 24.705" E	49° 57' 57.597" N
25			92° 4' 24.269" E	49° 57' 56.684" N
26			92° 4' 18.352" E	49° 57' 58.633" N
27			92° 4' 13.448" E	49° 57' 59.885" N
28			92° 4' 17.851" E	49° 58' 5.357" N
29			92° 4' 17.656" E	49° 58' 9.362" N
30			92° 4' 16.984" E	49° 58' 13.259" N
31			92° 4' 6.587" E	49° 58' 19.014" N
32			92° 4' 2.265" E	49° 58' 16.292" N
33			92° 3' 57.317" E	49° 58' 19.193" N
34			92° 3' 57.460" E	49° 58' 19.506" N
35			92° 3' 57.245" E	49° 58' 20.064" N
36			92° 3' 46.750" E	49° 58' 24.856" N
37			92° 2' 59.741" E	49° 58' 44.842" N
38			92° 2' 58.717" E	49° 58' 45.358" N
39			92° 2' 58.510" E	49° 58' 45.687" N
40			92° 3' 1.399" E	49° 58' 51.662" N
41			92° 3' 5.222" E	49° 58' 58.934" N
42			92° 3' 17.711" E	49° 59' 10.468" N
43			92° 3' 32.518" E	49° 59' 23.048" N
44			92° 3' 51.112" E	49° 59' 39.009" N
45			92° 3' 59.142" E	49° 59' 37.822" N
46			92° 3' 59.601" E	49° 59' 38.574" N
47			92° 4' 0.342" E	49° 59' 38.914" N

48			92° 4' 5.425" E	49° 59' 38.969" N
49			92° 4' 11.882" E	49° 59' 38.342" N
50			92° 4' 18.160" E	49° 59' 38.309" N
51			92° 4' 21.357" E	49° 59' 38.897" N
52			92° 4' 30.205" E	49° 59' 33.521" N
53			92° 4' 30.415" E	49° 59' 32.343" N
54			92° 4' 31.103" E	49° 59' 31.749" N
55			92° 4' 34.986" E	49° 59' 29.692" N
56			92° 4' 45.464" E	49° 59' 27.017" N
57			92° 4' 52.978" E	49° 59' 23.820" N
58			92° 4' 56.463" E	49° 59' 21.934" N
59			92° 5' 2.922" E	49° 59' 16.969" N
1		2 дугаар бүсэд 1 дүгээр бүсэд орсон сумын төвийн 3,4,5,7,10,11,12-р багуудын инженерийн шугам сүлжээ бүхий газраас бусад .	92° 5' 2.922" E	49° 59' 16.969" N
2		Эргэлтийн цэгийн эхлэл нь 2 дугаар багийн нутаг улаан уулын далангаас доош наадмын талбайн дээд талын далангын хорооллын арын голоор яваад гурлийн үйлдвэрийн арын голын урд талын хэсэг ороод Шунхай ШТС-ийн ард талаас 6 дугаар багийн хилийн цэсийн дагуу явж жишиг хороололын дээд талын шороон зам дагуу бага сургуулийн доод талын засмал зам дагуу урд уулзвар хүрээд Буянт хорооллын 2 дахь сайжруулсан шороон замын урд уулзвар хүрээд, Магнай трейд агуулахын урд талын гороон замаар явж , Дулааны 1-р станцын урд талын шороон замаар дээш Дашваанжил ШТС-ийн ард талаар дээш ногооны талбайн ард талын хэсэг Мөн далангаар дээш Алдраагын доод талын гарам хүрээд , Улаан уулын пост хүрсэн шороон замаар яваад постноос доош газар хөдлөлтийн доод талын айлууд ороод улаан уулын рашаан явах шороон замаар 2 дугаар багийн далан хүрнэ.	92° 4' 56.463" E	49° 59' 21.934" N
3			92° 4' 52.978" E	49° 59' 23.820" N
4			92° 4' 45.464" E	49° 59' 27.017" N
5			92° 4' 34.986" E	49° 59' 29.692" N
6			92° 4' 31.103" E	49° 59' 31.749" N
7			92° 4' 30.415" E	49° 59' 32.343" N
8			92° 4' 30.205" E	49° 59' 33.521" N
9			92° 4' 21.357" E	49° 59' 38.897" N
10			92° 4' 18.160" E	49° 59' 38.309" N
11			92° 4' 11.882" E	49° 59' 38.342" N
12			92° 4' 5.425" E	49° 59' 38.969" N
13			92° 4' 0.342" E	49° 59' 38.914" N
14			92° 3' 59.601" E	49° 59' 38.574" N
15			92° 3' 59.142" E	49° 59' 37.822" N
16			92° 3' 51.112" E	49° 59' 39.009" N
17			92° 3' 32.518" E	49° 59' 23.048" N
18			92° 3' 17.711" E	49° 59' 10.468" N
19			92° 3' 5.222" E	49° 58' 58.934" N
20			92° 3' 1.399" E	49° 58' 51.662" N
21			92° 2' 58.510" E	49° 58' 45.687" N
22		92° 2' 58.717" E	49° 58' 45.358" N	
23		92° 2' 59.741" E	49° 58' 44.842" N	
24		92° 3' 46.750" E	49° 58' 24.856" N	
25		92° 3' 57.245" E	49° 58' 20.064" N	
26		92° 3' 57.460" E	49° 58' 19.506" N	
27		92° 3' 57.317" E	49° 58' 19.193" N	
28		92° 4' 2.265" E	49° 58' 16.292" N	
29		92° 4' 6.587" E	49° 58' 19.014" N	
30		92° 4' 16.984" E	49° 58' 13.259" N	
31		92° 4' 17.656" E	49° 58' 9.362" N	
32		92° 4' 17.851" E	49° 58' 5.357" N	
33		92° 4' 13.448" E	49° 57' 59.885" N	
34		92° 4' 18.352" E	49° 57' 58.633" N	
35		92° 4' 24.269" E	49° 57' 56.684" N	
36		92° 4' 24.705" E	49° 57' 57.597" N	
37		92° 4' 29.525" E	49° 57' 56.656" N	
38		92° 4' 30.842" E	49° 57' 56.452" N	
39		92° 4' 31.955" E	49° 57' 59.034" N	
40		92° 4' 33.257" E	49° 58' 15.554" N	
41		92° 4' 36.196" E	49° 58' 15.780" N	
42		92° 4' 39.566" E	49° 58' 16.971" N	
43		92° 4' 50.549" E	49° 58' 18.733" N	

44	
45	
46	
47	
48	
49	
50	
51	
52	
53	
54	
55	
56	
57	
58	
59	
60	
61	
62	
63	
64	
65	
66	
67	
68	
69	
70	
71	
72	
73	
74	
75	
76	
77	
78	
79	2-р бҮС
80	
81	
82	
83	
84	
85	
86	
87	
88	
89	
90	
91	
92	
93	
94	
95	
96	
97	
98	
99	

92° 4' 57.345" E	49° 58' 17.029" N
92° 5' 0.160" E	49° 58' 21.864" N
92° 5' 1.281" E	49° 58' 23.545" N
92° 5' 5.962" E	49° 58' 31.934" N
92° 5' 9.871" E	49° 58' 41.149" N
